

АНС-ийн эцэг, эхчүүдийн академийн видео танилцуулга

Энэхүү видеог Арлингтоны Нийтийн Сургуулиуд дахь Англи хэл суралцагчдийн албанаас эрхлэн гаргав. Энэхүү мэдээлэл нь Арлингтоны сургалтын удирдлагын тогтолцооны Canvas програмыг хэрхэн ашиглах тухай товч танилцуулга бөгөөд зайны сургалтын үед онлайн зааварчилгаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх, зохион байгуулалтанд туслах зорилгоор судлах, танилцах програм дээр оюутнууд ашиглаж болно. Энэхүү мэдээллийг оюутан, эцэг эхчүүдэд зориулан бүтээв.

Англи хэл суралцагчдийн алба: зайны сургалтын мэдээллийг шинэчлэх тухай

00:02

Арлингтоны нийтийн сургуулиудын эцэг эхчүүдийн академид тавтай морилно уу.

00:05

Миний нэр Сэм Клайн. Би бол англи хэл суралцагчдын албаны ахлагч, менежер байна.

00:08

Та бүхэн одоо англи хэл суралцагчдийн эцэг эхчүүдэд зориулсан Эцэг Эхчүүдийн Академийн үйл ажиллагаанд оролцож байна.

00:12

Энд хүрэлцсэн ирсэн та бүхэнд баярлалаа.

00:15

Та бүхнийг энд хүрэлцэн ирж, APS-ийн гэр бүл болж байгаад баяртай байна.

00:19

Та бүхэн дэлгэцэнд анхаарлаа хандуулна уу.

00:23

Та бүхэн бидний бэлтгэсэн танилцуулгыг үзээрэй.

00:27

Би та бүхэнтэй англи хэл суралцагчдад зориулсан үйл ажиллагаа

00:30

Мөн зайны сургалтын үеэр та бүхний хийх боломжтой зүйлс,

00:32

Бидний үйл ажиллагааны одоогийн нөхцөл байдлын талаар бага сага мэдээлэл өгөхийг хүсэж байна.

00:36

Нэгдүгээрт хамгийн түгээмэл асуултуудын нэг бол

00:42

би хүүхдээ англи хэл суралцагчдад зориулсан үйл ажиллагаанд боломжтой эсэхийг хэрхэн тодорхойлох вэ ?

00:44

Сайхан асуулт байна. АНУ-д хүүхдийг сургуульд бүртгэх үед

00:48

элсэгчид эх хэлний судалгаанд хамрагдах тухай хууль байдаг.

00:52

Виржиниад манай сургуулиудын системд

00:56

мөн адил эх хэлний судалгаа хийдэг.

00:59

Хэрвээ эцэг эхчүүд аль нэг асуултанд “тийм” гэж хариулсан бол,

01:02

хүүхдийн ярьдаг эх хэл болон бусад хэлний талаар

01:06

дэлгэрүүлэн асуудаг.

01:08

Хэрвээ элсэгчид аль нэг асуултанд тийм гэж хариулсан бол

01:13

хүүхдээс Англи хэлний түвшин тогтоох шалгалт авдаг.

01:16

Энэхүү WIDA шалгалт нь:

01:20

хүүхэд 1 - 2 - 3 – 4 түвшин эсвэл өндөр дээд түвшин эсэхийг тодорхойлох,

01:25

эсвэл англи хэлний сургалт шаардлагагүй эсэхийг тодорхойлно.

Эцэг эх англи хэлний сургалтаас татгалзаж болно.

01:30

Гэхдээ бид жил бүрэн

01:35

ELs-ийн англи хэлний түвшин тогтоох WIDA шалгалт зарладаг.

01:39

Англи хэл сурч байгаа бүх сурагчид

01:43

бүгд адилхан шалгалтанд оролцох шаардлагатай.

01:47

Жил бүрэн эдгээр шалгалтыг нэг, гуравдугаар сарын хооронд зохион байгуулдаг,

01:51

ингэснээр багш нарт маш их мэдээлэл өгдөг.

01:54

Ингэснээр таны хүүхдэд заах, сургах гол арга замуудыг нарийн тодорхойлдог.

01:59

Мөн үүнээс гадна англи хэлний түвшин ахиж байгаа эсэх,

02:03

англи хэлний түвшин сайжирсан

02:06

эсэхийг мэдэх боломжтой.

02:09

Шалгалтын гол чиглэлүүд нь тодорхой сэдвээр

02:13

унших, бичих, ярих, сонсох юм.

02:17

Тэгвэл шалгалтанд оролцохгүй бол яах вэ? Зүйтэй асуулт.

02:20

шалгалт авч,

02:24

оюутны түвшин 1-2-3-4 эсвэл англи хэлний өндөр түвшин эсэхийг тодорхойлно.

02:27

Түвшин 1 бол өмнө нь англи хэл сурч байгаагүй сурагчид буюу ихэнх сурагчдад хамаарна.

02:31

англи хэл сурах сурагчдийн хувьд

02:34

дараа жил нь шалгалтанд авах үед

02:37

сурагчид түвшин 2 эсвэл түвшин 3 хүртэл ахисан байж болно.

02:42

Улмаар түвшнүүд ахиж, түвшин 6 буюу дээд түвшин хүртэл ахиж болно.

02:46

6-р түвшин хүртэл.

02:47

6-р түвшин бол мэргэжлийн түвшин юм.

02:51

Гэхдээ бүх сурагчид академик англи хэлийг судалдаг.

02:55

Иймээс бүх сурагчид оноо авсан байх ёстой. Энэхүү видео танилцуулгын 2:55 минут хэсэгт онооны талаар танилцуулсан.

03:00

Эцэг эх онооны талаар мэдээлэл авна.

03:04

Сургуулиуд сургууль дээрээ сурагчдийн онооны талаар танилцуулна.

03:08

Багш нар эдгээр асуудалд тусгайлан анхаарал хандуулдаг. Яагаад гэвэл

03:12

та доор улаанаар дугуйлсан зүйлд анхаарлаа хандуулаарай,

03:16

энэ бол нийт оноо. Иймээс 3.4 оноо бол L түвшин 3-д хамаарна.

03:21

Гэхдээ эдгээр оноонууд нь

03:25

сонсох,

03:26

ярих, унших, бичих аль алинд ижил биш.

03:28

Энэ нь багш өөрийн оюутан сонсох чадвар өндөр эсэхийг

03:33

мэдэхэд тусална. Энд 4.0 гэсэн жишээг авчээ.

03:36

Тэгвэл тухайн сурагч ярих чадвартай.

03:40

Сурагчдийн чадварыг бүрдүүлэхтэй адилаар багш нар

03:45

үүнтэй төстэй нөхцөл байдлуудад ажилладаг.

03:47

Нэмэлт харилцан яриаг сонсох нь

03:51

сурагчид ярих чадвараа ахиулах

03:55

боломжийг олгоно.

03:57

Миний өмнө дурдсанчлан WIDA бол шалгалт.

04:01

Гэхдээ мөн стандартуудын бүрдэл бөгөөд WIDA-ийн нэг чухал зүйл

04:05

бол бидний “тодорхойлогчууд” гэж нэрлэдэг зүйлс юм.

04:09

Энэ нь багш нараас хамаарах асуудал. Иймээс багш нар “аа, энэ оюутан 3.4 оноотой” үзвэл,

04:13

тухайн сурагчийн сонсох чадвар 4 байна. Энэ бол тухай сурагчдийн хийж чадах зүйлс юм.

04:17

Мэдээж энд бичигдсэн бүх зүйлс

04:21

бүх оюутанд яг адилхан биш.

04:24

Учир нь оюутан бүхэн адилгүй, ялгаатай. Гэхдээ энэхүү түвшний мэдээлэл нь:

04:27

багш нарт чухал ач холбогдолтой.

04:31

Багш нар оюутанд нэмэлт тусламж шаардлагатай эсэхийг мэдэхэд,

04:34

сурагчид унших, бичих,

04:37

мөн сонсох чадвараа ахиулахад чухал ач холбогдолтой.

04:39

Иймээс би англи хэлний багш нарын үүрэг, үйл ажиллагааны талаар

04:43

Хоёр зүйл ярихыг хүсэж байна. Би одоо энэ тухай цөөн хэдэн үгээр тайлбарлая..

04:47

Анхан шатанд англи хэлний багш нар

04:50

анги багш нартай нягт хамтран ажилладаг. Хоёрдугаар анги,

04:53

дөрөвдүгээр анги гэх мэтээр багш нартай хамтран ажилладаг.

04:55

Иймд Англи Хэлний багш гарын үүрэг бол

04:59

Англи хэлний түвшинг сайжруулахад анхаарах явдал юм.

05:02

Багш нар ангийн багш нартай хамтран ажиллаж,

05:06

улмаар ангийн багш нар бутархай, усны төлөв байдал

05:09

зэрэг тодорхой сэдвүүдэд илүү их анхаардаг.

05:13

Англи хэлний багш нар тухайн сэдвээр хэлний чадварыг ахиулахад анхаардаг.

05:16

ихэнх цагуудад англи хэлний багш нар ангид хичээл орж,

05:21

сурагчидтай хамтран ажилладаг. Иймээс сурагчидтай ажилладаг

05:25

хоёр багш байна.

05:26

Гэхдээ Англи хэлний багш нар зарим сэдвээр

05:29

англи хэл сурагчдын сонгон ажиллах тохиолдлууд байна.

05:33

Дунд сургуульд манай хөтөлбөр бага зэрэг ялгаатай.

05:40

Дунд сургууль болон ахлах сургуульд зориулсан сурагчдийн хуваарь анхаарлаа хандуулбал,

05:44

нэг, хоёрдугаар улиралд суралцах,

05:51

мөн нэг, хоёрдугаар түвшинд хамаарна. Сурагчид хэлний чиглэлээр Англи Хэлний Түвшинг Ахиулах Анги,

05:55

Эсвэл хэлний чиглэлээр хоёр хичээлд хамрагдаж болно.

05:58

Сурагчид шинжлэх ухаан, нийгмийн ухааны нэг хичээл орно.

06:01

Мөн сурагч шинжлэх ухааны хичээл орох үеэр хамтран суралцаж болно.

06:10

Хичээлийг хамтран заалгаж болно.

06:13

Иймээс та бүхэн шинжлэх ухааны хичээлийн багш,

06:17

англи хэлний хичээлийн багштай. Англи хэлний багш нар

06:20

англи хэлний түвшинг ахиулахад анхаарна.

06:22

Харин шинжлэх ухааны хичээлийн багш нар шинжлэх ухааны хичээлүүдэд анхаарал хандуулна.

06:26

Хэдийгээр багш нар шинжлэх ухаан, хэл гэсэн

06:30

аль аль чиглэлээр ойлгох боловч

06:31

тэд хамтран ажилладаг.

06:33

Манайд Англи хэлний нөөц багш нар гэж нэрлэгдсэн

06:37

төрөлжсөн багш нар бий. Тэд зөвхөн дунд сургуульд хичээл ордог.

06:40

Тэд англи хэл сургалтын алба, Ed албанд хамаарах

06:43

сурагчидтай хамтран ажилладаг.

06:47

Хэрвээ танд асуулт байгаа бол ...

06:51

хэрвээ танай хүүхэд эдгээр албанд давхар хамаардаг, танд англи хэлний нэмэлт багш нар байгаа бол

06:55

сургуульд хандана уу. Танд тэдний үйл ажиллагааны талаар

06:58

асуулт байгаа бол тэд сурагчдийн бүх хүсэлт шаардлагад

07:02

бодитоор анхаарал хандуулна.

07:04

Хэлний түвшинг сайжруулахтай холбоотой бүх агуулга, хүсэлт шаардлагыг

07:07

Ханган ажиллана.

07:10

Манайд сургуулийн үйл ажиллагаанд чухалд тооцогддог

07:14

хоёр ажил үүрэг, албан тушаал байдаг.

07:18

Тэдгээрийн нэг нь зөвлөх юм. Англи хэлний зөвлөх нь

07:22

дунд ба ахлах сургуулиудад ажилладаг,

07:26

тэдний гол үүрэг бол өмнө нь тахлын үед

07:28

өвдөж байсан эсвэл өөр хүндрэл асуудал тулгарч байсан англи хэлний сурагчдад туслах явдал юм.

07:32

Олон оюутнуудад нийгэм, сэтгэл зүйн тусламж шаардлагатай.

07:36

Англи хэлний зөвлөхийн үүрэг бол

07:39

Тэдэнд туслах явдал юм.

07:40

Англи хэлний зөвлөхүүд хоёр хэлтэй,

07:44

Тэд соёлын ялгааг даван туулахад сурагчдад тусалдаг.

07:47

Жишээ нь: сурагч шинэ оронд ирээд,

07:51

өөр зүйл, өөр соёлыг хардаг,

07:54

сурагчид хэсэг хугацаанд эцэг эх, гэр бүлээсээ тусдаа байдаг,

07:58

тэгээд буцаад гэр бүлтэйгээ уулздаг.

08:01

ингэж буцаж уулзах нь үнэхээр сайхан. Гэхдээ зарим оюутан, эцэг эхчүүдэд энэ нь хэцүү байдаг.

08:04

Англи хэлний зөвлөхүүд оюутан, тэдний гэр бүл

08:07

хамт байх, хамтран ажиллахад хэрхэн туслах талаар суралцсан.

08:10

Хамгийн чухал нь Англи хэлний зөвлөхүүд бол

08:13

ямар ч сургуулийн зөвлөх багийн хамгийн чухал гишүүн,

08:17

тэд оюутны нийгэм, сэтгэл санааны өөрчлөлт, хөгжил,

08:20

хүүхдийн нийгэм, сэтгэл санааны байдалд хэрхэн хандах талаар сайн мэднэ.

08:23

Иймээс та сургууль, Англи хэлний зөвлөхтэй холбогдоно уу.

08:27

Тэд тантай хамтран ажиллахдаа баяртай байх болно.

08:32

Манай сургуулийн өөр бас нэг чухал үүрэг бол хоёр өөр хэлтэй гэр бүлийг холбох явдал юм.

08:36

Хоёр өөр гэр бүлийн хамтын ажиллагаа бол

08:40

ямар ч гэр бүлд нээлттэй,

08:45

бөгөөд сургуулийн үйл ажиллагаанд оролцоход тусалдаг,

08:49

хүүхдийн боловсролд туслалцаа үзүүлдэг. Хос хэлтэй гэр бүл

08:52

сургуульд сурах үед шинэ цагаач гэр бүлд зочилдог.

08:55

Тэд хэрхэн сургуульд элсэхэд тусалдаг,

08:59

шаардлагатай бол аялал зохион байгуулдаг.

09:02

Гэхдээ сургууль болон олон нийтийн хоорондох хамтын ажиллагаа юм.

09:04

Манай BFL's, хос хэлтэй гэр бүлүүд

09:07

олон асуудалд туслалцаа үзүүлж, эцэг эхчүүдтэй уулзаж,

09:10

эцэг эхчүүдийг аль болох өргөн хэмжээнд сургуулийн үйл ажиллагаанд оролцуулдаг.

09:12

Мөн хос хэлтэй гэр бүлийн хамтын ажиллагааны хүрээнд

09:16

хөтөлбөр хэрэгжүүлж, миний өмнө нь хэлсний дагуу гэр бүлийг дахин уулзуулж,

09:19

үе тэнгийн хүмүүстэй хэрхэн харилцах арга замуудыг зааж өгдөг.

09:23

Тэд олон чухал үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Миний та бүхэнд санал болгох зүйл бол

09:27

та хос хэлтэй гэр бүлийн хамтын ажиллагааны талаар мэдэхгүй бол

09:30

Сургуультай холбоо барьж, хос хэлтэй гэр бүлийн хамтын ажиллагааны талаар асуугаарай.

09:33

Тэд та бүхэнтэй хамтран ажиллаж, сургуультай холбогдох талаар туслана.

09:37

Гэхдээ хамгийн чухал нь

09:40

танд асуух зүйл байгаа бол тэд түүнийг талархан хүлээн авч,

09:44

таныг Англи Хэлний Зөвлөх эсвэл Ерөнхий боловсролын зөвлөх,

09:48

эсвэл манай зааварлагчтай холбож өгнө.

09:51

Тэд таныг хэнтэй холбогдох талаар сайн мэднэ.

09:57

Иймээс манай англи хэлний албаны ажилтны хувьд

10:01

Би өмнө нь тэдний талаар өмнө нь танилцуулж байсан.

Би өмнө нь ярьж байсны адилаар

10:05

бага сургуульд тэдэнтэй илүү их хамтран ажиллахыг хүсэж байна.

10:09

Англи хэлний багш нар цэцэрлэг эсвэл гуравдугаар ангид хичээл ордог.

10:13

Ангийн багш болон англи хэлний багш төлөвлөгөө гаргаж, хамтран ажилладаг.

10:18

Англи хэлний багш нар англи хэлний түвшинг

10:22

Сайжруулахад анхаарлаа хандуулдаг.

10:25

Ангийн багш нар тодорхой хичээлүүдэд анхаарал хандуулдаг.

10:27

Заримдаа англи хэлний багш нар

10:30

ангид англи хэлний сурагчидийн сонгон ангитай ажиллаж,

10:34

зарим тохиолдолд зайны сургалтын үед

10:38

англи хэлний цөөн тооны сурагчид бүхий ангийг байгуулж болно.

10:40

Би зарим ялгаатай зүйлсийн талаар цөөн хэдэн үг хэлэхийг хүсэж байна.

10:44

Англи хэлний багш нарын өөр нэг үүрэг бол

10:47

ерөнхий боловсролын багш нар,

10:51

мэргэжилтнүүдэд зөвлөгөө өгөх, санал солилцож,

10:54

“Англи хэлний сурагчидтай хамтран ажиллах тодорхой стратеги”-ийг санал болгох юм.

10:57

Хоёрдугаарт дахиад хэлэхэд манай анги дотоод бүрэлдэхүүнтэй.

11:01

Тэд англи хэлний багш нарын заах нэгэн ижил хичээлээр

11:04

хэл болон бусад хичээлийг судалдаг.

11:08

Иймээс тэд англи хэлний түвшнээ ахиулахын зэрэгцээ өөр бусад хичээлийг давхар судалж,

11:10

давхар суралцах боломжтой. Жишээ нь:

11:14

Миний өмнө нь хэлсэнчлэн, шинжлэх ухааны хичээлийн багш нар,

11:18

Англи хэлний багш нар хэл болон бусад хичээлээр хамтран ажилладаг.

11:23

Зайны сургалт. Хаврын зайны сургалт

11:26

намрын зайны сургалтаас бага зэрэг ялгаатай,

11:30

хавар хийснээс бага зэрэг ялгаатай. Манай багш нар

11:34

хичээлээ англи хэлний орчинг бүрдүүлэх,

11:38

хичээлүүдийг судлахын зэрэгцээ

11:41

хэлээ сайжруулах боломжийг бүрдүүлэхэд маш их хичээн ажилладаг.

11:45

Миний ярих нэг зүйл бол

11:49

англи хэлний багш нар ангид хичээл ордог.

11:52

зайны сургалтанд

11:55

тэд том хэмжээний ангид хичээлээ үргэлжлүүлэн орохын зэрэгцээ,

11:59

гэхдээ бусад цагуудад жижиг группийн ангиудад хичээл ордог.

12:04

Үүний шалтгаан нь

12:09

унших, бичих, ярих, сонсох зэрэг хэлний

12:13

дөрвөн чиглэлээр группийн ангид хичээл ордог.

12:16

Нарийвчлан хэлбэл жижиг группийн анги байгуулснаар

12:19

Англи хэлний багш нар сурагчидтай тодорхой нэг хичээл, сэдвээр

12:22

илүү их хамтран ажиллах,

12:23

харилцах боломж бүрддэг. Энэ нь ямар учиртай юм бэ?

12:26

Группийн анги гэдэг нь хоёр эсвэл гурван сурагч тодорхой нэг хичээл, сэдвээр харилцан санал солилцдог.

12:30

Энэхүү ярилцлага нь үзсэн зүйлээ асуух, хариулах байдлаар явагдана. Энгийн нэг асуулт биш.

12:33

Жишээ нь усны төлөв байдал гэж юу вэ?

12:38

Энэ сэдвээр илүү дэлгэрэнгүй ярилцана. Жишээ нь

12:41

тэд ургамлын талаар ярилцаж байгаа бол нэг оюутан “ургамал ургахад юу хэрэгтэй вэ” гэж асуухад

12:45

Өөр нэг сурагч “нарны гэрэл чухал хэрэгтэй зүйлсийн нэг” гэж хариулна.

12:49

“Нарны гэрэл ямар хэрэгтэй вэ” гэж асуухад

12:52

Өөр нэг сурагч “өөр ямар зүйл хэрэгтэй вэ” гэх зэргээр асууна.

12:55

Сурагчид “ургамал шим тэжээлээ авахад хөрс хэрэгтэй” гэж хариулна.

12:59

“Таны бодлоор өөр ямар зүйл хэрэгтэй вэ” гэх мэтээр

13:02

нэг сурагч асууж, хариулах байдлаар явагдана.

13:06

Группийн анги бол сурагчид хэлээ сайжруулахад чухал үүрэгтэй.

13:10

Сурагчид тодорхой сэдвээр судалж, хэлээ сайжруулна.

13:13

Зайны сургалтанд жижиг сонгон ангиуд нь

13:16

сурагчид хоорондоо санал солилцох, ярилцах боломжийг олгоно.

13:19

Дунд сургуульд анги нь нэг, хоёр, гуравдугаар улирал

13:23

гэх мэтээр хичээллэдэг учраас,

13:26

эдгээр ангиуд нь англи хэлний багш нарын нэгэн ижил аргаар

13:29

онлайнаар явагдана.

13:33

Мөн нэгэн адил жижгэвтэр группээр суралцдаг.

13:38

Таны бодож байгаатай адилаар

13:41

том хэмжээний групп анги нь жижиг группууд шиг харилцан боломж багатай.

13:45

Жижгэвтэр групп байгуулснаар

13:49

бүтээлч, бие биенээ дэмжсэн байдлаар ажилладаг.

13:50

Тодорхой нэг сэдвээр харилцан ярилцах боломжийг бүрдүүлэх нь

13:53

сурагчдад маш чухал ач холбогдолтой. Үүнээс гадна,

13:57

энэ нь англи хэлний сурагч нэг бүрийн

14:01

унших, бичихэд цаг гаргах боломжийг олгоно.

14:06

Ерөнхийдөө Арлингтоны Олон Нийтийн Сургуульд

14:10

ангийн хичээлээр тодорхой сэдэвт зорилгын дагуу түлхүү ярилцдаг.

14:14

Багш хичээлийн төлөвлөгөөг бичихдээ тухайн сэдэвт хамаарах хэлний шаардлагууд, зорилгыг тодорхойлох хэрэгтэй.

14:18

Сэдвийн зорилгоос эхлэе.

14:22

Нийгэм судлалын багш байна гэж бодъё.

14:25

Багш баруун руу чиглэсэн цагаачлалын талаар ярьж байна.

14:28

Тэгвэл энэ сэдвийн зорилго юу вэ?

14:32

Энэ сэдвийн чухал асуудлууд юу вэ? Хэлний хэрэгцээ, зорилгын хувьд

14:36

сурагчид өөрийн санал бодлоо илэрхийлнэ.

14:38

Баруун руу чиглэсэн цагаачлалын талаар тэдний сурах эзэмших зүйлс юу вэ ?

14:41

Сургалтын зорилго. Хэлний зорилтын хувьд

14:44

сонсох, ярих, унших, бичих зүйлс багтана.

14:47

Сурагчдийг хариултаа бичихийг хүсэх нь хэлний даалгавар, зорилтын нэг жишээ юм.

14:51

Хичээл бүр тодорхой агуулгатай, хэлний бүрэлдэхүүнтэй.

14:55

Арлингтоны Олон Нийтийн Сургуулиудад

14:59

Бүх хичээлд хэлний дөрвөн бүрэлдэхүүнийг бүрэн хамрахгүй боловч

15:03

Хэлний дөрвөн чухал бүрэлдэхүүнийг хамруулахыг хүсдэг.

15:07

Заримдаа гурван бүрэлдэхүүн хамардаг.

15:12

Нэг өдөр нь унших, хариулах байдлаар явагдаж болно. Унших, бичих байдлаар явагдаж болно.

15:17

Зайны сургалтанд та хүүхдэдээ туслахад ашиглаж болох

15:22

цөөн хэдэн зөвлөгөө байна. Энэ өнгөрсөн жил хүүхэд нь сурч байсан эцэг эхчүүдээс энэ зөвлөгөөг гаргасан.

15:26

Миний хүүхэд өнгөрсөн жил ахлах сургуульд сурч байсан,

15:30

Манай хүүхдийн туршлагаас үндэслэн эдгээр зарим зүйлсийг санал болгож байна.

15:35

Нэг чухал зүйл гэвэл хүүхдүүд зун гадаа тоглох,

15:39

цагийг зугаатай өнгөрөөхийг хүсдэг нь бодит үнэн.

15:42

Одоо бол өдөр хичээлдээ цаг гаргах чухал цаг үе.

15:46

Хичээл, сургуулийн цагтаа анхаарч, цагийг нарийн зохион байгуулаарай.

15:50

Би байр руугаа яваагүй байна гэж тэд бодож байгаа.

15:53

Энэхүү нарийн тодорхой цагуудад юу хийх хэрэгтэй вэ ? Сургууль нь өөрийн гэсэн нарийн хуваарь, хөтөлбөртэй.

15:57

таны хийж чадах нэг зүйл бол хуваарь, төлөвлөгөө гаргахад туслах явдал юм.

16:00

Хүүхдэдээ зориулж ханан дээр өлгөх, наах хуваарийн хувьд:

16:04

Нэгдүгээрт: Сэрэх цаг. Сэрэх цаг тодорхой байх ёстой.

16:07

“Эрүүл зөв өглөөний цайгаар эхлээрэй”.

16:11

Дараа нь өглөөний дасгал, өглөөний зууш,

16:14

дасгал хөдөлгөөнд цаг гаргана.

16:18

Сурагчид босох, алхах, завсарлага авах хэрэгтэй гэдгийг ойлгуулах нь чухал.

16:20

Дасгалаа хийгээд компьютерын өмнө энд сууж байгаа миний хувьд

16:24

нэг цаг бүрт сунгалт хийх, дасгал хийх цаг гаргадаг.

16:27

Би хэдэн дасгал хийгээд,

16:30

жаахан зууш иддэг.

16:32

Таны хийж болох нэг зүйл бол нам гүм амар тайван орчныг бүрдүүлэх явдал юм.

16:36

Та дэлгэцийн зүүн гар талд анхаарлаа хандуулбал,

16:40

хоёр тэмдэг байна. Эхний нь “Чимээгүй орон зай”,

16:43

нөгөө тэмдэг нь “чимээгүй байна, ажил хийж байна” гэсэн тэмдэг.

16:47

Үүнтэй адил тэмдэг хийж, оюутнууд сурч, хичээл хийж байгаа газарт тавиарай.

16:51

Хэрвээ сурагч хоол идэх өрөө, гал тогооны өрөө эсвэл буйдан дээр

16:54

эсвэл өөрийнхөө унтлагын өрөөндөө хичээл хийж байгаа бол

16:58

гэрийн бусад хүмүүст хүүхэд хичээл хийж байгааг сануулах тэмдэг байрлуулж болно.

17:01

Хичээлийн цаг. Чимээгүй байгаарай гэх мэт.

17:03

Хэрвээ боломжтой бол хичээлийн цагаар

17:07

Хичээлийн цаг явагдаж байна, чимээгүй байгаарай гэдгийг сануулж болно.

17:11

Мэдээж завсарлагааны үеэр бусад хүмүүс арай чанга санал солилцож, ярилцаж болно.

17:14

Эсвэл зурагт үзэж, дуу сонсож болно.

17:18

Гэхдээ хичээлийн цагаар буюу сурагч гэрийн даалгавраа хийж байх үеэр

17:21

чимээгүй орон зайг гаргах, чимээгүй байх нь зүйтэй.

17:25

Одоо бас нэг чухал зүйл бол хүүхдэдээ ажиллах, сурах орон зайг гаргах явдал юм.

17:28

Сурагч хичээлийн хэрэгслээ тавих ширээ,

17:32

тэдгээрийг тавих зай, тавцан,

17:34

компьютер, таблет, бичих зай, талбай хэрэгтэй.

17:38

Мөн зарим математикийн бодлогыг цаасан дээр зурж тэмдэглэх хэрэгтэй.

17:41

Сурч байгаа зүйлээ бодитоор бичиж тэмдэглэх хэрэгтэй.

17:44

Нөхөрсөг сануулга болгон миний дэргэд нэг шил ус байлгахыг

17:47

би үргэлж зөвлөдөг.

17:51

Энэ нь ам хатахгүй байх, илүү эрч хүчтэй сурахад тусална.

17:54

Тэгээд эцэст нь хэлэхэд анхаарал сарнилтыг багасгах хэрэгтэй.

17:57

Таны хажууд зурагт байгаа бол

18:01

дууг нь хаах эсвэл унтраах хэрэгтэй.

18:04

Анхаарал нь амархан сарнидаг хүүхэдтэй бол

18:07

тоглоом, компьютер тоглоомоос холдуулж,

18:10

хичээлийн үеэр анхаарал сарних, уруу татах зүйлгүй байх хэрэгтэй.

18:14

эцэст нь хэлэхэд хичээлийн цаг бол

18:18

сурагч, эцэг эх, багш бид бүгдэд нэгэн адил нэлээд амаргүй зүйл.

18:22

Иймээс сурагч хүнд хэцүү зүйлийг даван туулахад эелдэг нөхөрсөг сонсогч байж, сайн туслагч нь байгаарай.

18:25

Хэрвээ энэ тухай асуух зүйл байгаа бол би таныг хэнтэй холбогдохыг хэлж зөвлөнө.

18:29

Хэрвээ сургуультай холбогдох эсэх талаар сайн мэдэхгүй байгаа бол

18:33

юуны түрүүнд

18:37

хос хэлтэй гэр бүлийн хамтын ажиллагаанаас эхлэх нь зүйтэй.

18:41

Тэд таныг зохих хүнтэй холбож өгнө.

18:44

Танд туслах өөр нэг зүйл бол

18:45

зуны амралт, хичээлийн жилийн бусад амралтууд зэрэг

18:49

зайны сургалтаас бусад үед эх хэлээ үргэлжлүүлэн ашиглаж болно.

18:52

Таны хүүхэд англи хэлийг сурч байгаа гэдгийг бид бүгд ойлгох хэрэгтэй.

18:56

Гэхдээ хамгийн чухал нь

18:59

хүүхэд эх хэлээ үргэлжлүүлэн хэрэглэх, эх хэлээрээ бахархдаг байх хэрэгтэй.

19:02

судалгаанаас харахад

19:05

эх хэлээ сайн мэддэг,

19:08

унших, бичих чадвар сайтай хүүхэд энэ чадвараа англи хэл сурахад бүтээлчээр ашигладаг.

19:11

Сонсох, ярихын нэгэн адилаар эх хэлээ ашигласаар байх нь чухал юм.

19:14

Танд зориулсан өөр нэг хэлэх зүйл бол

19:16

бага насны хүүхдэд зориулан уншиж өгөх хэрэгтэй.

19:20

Та номыг эх хэлээрээ чангаар уншиж өгч болно.

19:23

Арлингтон Нийтийн Номын Санд олон хэлээр бичигдсэн ном хадгалагддаг.

19:26

Танай хүүхэд арай том бол хүүхдээ эх хэлээр нь ном уншуулаарай.

19:30

Бид гэртээ Англи, Испани хэлээр хүүхдээ яриулж өсгөсөн учраас

19:34

бид хүүхэдтэйгээр хамт хийх дуртай зүйл бол

19:37

бага байхад нь хүүхэдтэйгээ хөгжилтэй сэдвээр мэтгэлцдэг байсан.

19:40

Гоё амт, аяган кекс, жигнэмэг зэрэг зүйлсийн талаар ярилцаж болно.

19:43

Иймэрхүү сэдэв нь хүүхдэд илүү сонирхолтой, хөгжилтэй байдаг.

19:47

учир нь танай хүүхэд шоколад, зайрмагтай холбоотой

19:50

үгсийг эх хэлээрээ сайн мэдэхгүй шүү дээ.

19:53

Иймээс эдгээр зүйлсийн тухай ярилцах нь танд маш чухал юм.

19:57

үүнтэй төстэй өөр зүйл, сүүлийн үед болсон үйл явдал байж болно.

20:01

АНУ-д сонгууль болох гэж байна,

20:04

эсвэл өөр улсад сонгууль болох гэж байж магадгүй.

20:07

Энэ бол ярилцах том сэдэв. Энэ бол сүүлийн үеийн цаг үеийн чухал сэдэв.

20:10

Эцэст нь хэлэхэд энэ нь хуучны сургууль шиг сонсогдож байгааг бий ойлгож байна.

20:14

Гэр бүлийн хэн нэгэндээ захидал бичих,

20:17

эсвэл арай орчин үеийн байдлаар

20:19

гадаадад байгаа өөр хэн нэгэнд и-мэйл бичиг болно. Эх хэлээ ашигласнаар

20:22

сурагч эх хэлээрээ бичих боломж бүрдэнэ.

20:25

Тэмдэглэл хөтлөх нь эх хэлээ ашиглах өөр нэг жишээ юм.

20:28

Хүүхдийг эх хэлээрээ бахархах сэдлийг төрүүлэх,.

20:31

англи хэл сурахын хажуугаар

20:35

эх хэлний чадвараа хөгжүүлэх хэрэгтэй.

20:38

Ингээд эцэст нь таны асууж магадгүй зарим нэг санал

зөвлөмжүүдийг хүргэж байна.

20:42

бидний хүүхдүүдэд энэ нь маш амжилттай зүйл гэдгийг бид мэднэ.

20:45

Би хүүхдээ бага байхад нь, та нарын үе ямар сайхан байна аа

20:49

гэж хэлж магадгүй. Энэ тухай надад хэлэх зүйл их биш байна.

20:54

Хүүхдүүд та нарын цаг үе ямар сайхан байна гэж хэлэхийн оронд,

20:58

бидний хэлж болох хэд хэдэн зүйл байна.

21:02

жишээ нь таны саяхан сурсан инээд хүрэм зүйл чинь юу байсан эсэх,

21:06

таны инээдийг хүргэмээр бөгөөд саяхан сурсан юу байсан эсэх

21:08

Таны гайхшийг төрүүлсэн, саяхан сурсан зүйл юу байсан зэргийг ярьж болно.

21:13

Тэдэнд яагаад инээдтэй санагдсан, тэдэнд сонирхолтой санагдсан зүйлсийн талаар

21:18

тэднээр тайлбарлуулж болно.

21:22

Өөр нэг жишээ бол “өнөөдөр чи юу хийсэн бэ” гэдэг асуулт юм.

21:27

“Би мэдэхгүй”, эсвэл “юу ч хийгээгүй”, эсвэл “математикаа хийсэн”, эсвэл зарим товч хариулт байж болно.

21:31

Гэхдээ та янз бүрийн байдлаар асуусан,

21:36

“Сурсан хамгийн сонирхолтой хоёр зүйлээ хэлээрэй” гэж хүссэн бол

21:39

та илүү том өргөн сэдвээр ярилцах боломжтой.

21:42

“чи өмнө нь ерөөсөө хийж байгаагүй, өнөөдөр л анх хийсэн ямар зүйл байна” гэсэн асуулт байж болно.

21:46

Энэ асуулт нь мөн өргөн том ярилцлага болно.

21:50

“Өнөөдөр юу хөгжилтэй байсан бэ ?” гэх асуухын оронд

22:06

Баасан, Пүрэв гаригт болсон зүйлсийг асууж болно.

22:09

Тодорхой нэг сэдвээр ярилцаж, илүү дэлгэрэнгүй байдлаар тайлбарлуулж болно.

22:12

энэ нь хоёр ач холбогдолтой. Нэгдүгээр эх хэлээ сайжруулах,

22:15

хоёрдугаарт хүүхдийн бодох сэтгэх хурдыг сайжруулдаг.

22:18

Мөн хүүхэд сургууль дээрээ өдрийг яаж өнгөрөөсөн тухай

22:20

мэдэх боломжийг олгоно.

22:23

Ингээд эцэст нь хэлэхэд таныг хэнтэй холбоо барих тухай санал солилцоё.

22:27

юуны өмнө хос хэлтэй гэр бүл гэж хэлмээр байна.

22:30

Танай хүүхдэд, эсвэл танд

22:33

хүүхдийн англи хэлний түвшингээ ахиулах талаар

22:38

асуулт байгаа бол

22:40

тэд таныг сургууль дээр зохих хүнтэй холбогдоход тусална.

22:43

Тэдэнд нэг биш хэд хэд байж болно. Гэхдээ та мэддэг багш нарынхаа тухай илүү ихийг мэдэх болно.

22:47

Бага сургуульд багшийн талаар илүү мэдээлэл авч болно.

22:50

Хэрвээ танай хүүхэд хоёрдугаар ангид сурч байгаа бол

22:53

хүүхдийнхээ ангийн багштай холбогдоорой.

22:58

Дараагийн ээлжинд эрүүл мэнд, биеийн тамир, математик, шинжлэх ухааны багштай холбогдоорой.

23:02

Хүүхдийнхээ сэтгэл санааны байдлын талаар асуух зүйл байгаа бол

23:06

асууж болно.

23:09

англи хэлний зөвлөхтэй мөн холбогдоорой.

23:13

хэдийгээр бидэнд зөвлөх гэж байхгүй боловч

23:16

бидэнд өөр зөвлөх байгаа шүү дээ.

23:19

Иймээс таныг зөвлөх рүү холбож өгч чадах

23:23

хос хэлтэй гэр бүлийн харилцааг ашиглаарай.

23:24

Хэрвээ танд хүүхдийн эрүүл мэнд, сэтгэл санааны талаар

23:28

асуух зүйл байгаа бол

23:31

Арлингтоны Нийтийн Сургуульд

23:34

танай хүүхдэд сайхан сэтгэгдэл төрүүлэхийг хичээх нь бидний хувьд маш чухал юм.

23:37

Үүнээс гадна нийгмийн ажилтан, сэтгэл зүйч байгаа.

23:40

Танай хүүхдэд тусалж чадах өөр ажилтнууд бас бий.

23:44

Арлингтон Нийтийн Сургуулийн Үйл Ажиллагааны Танилцуулга
Хуудас руу зочлох холбоосыг үзээрэй.

23:48

Энэ бол Арлингтоны Нийтийн Сургуультай

23:51

холбогдох сайхан боломж юм.

23:53

Англи хэл сурагчдийн эцэг эхчүүдэд зориулсан эцэг эхчүүдийн
академийн талаар танилцууллаа.

23:58

Энэ бүхэн танд тус болно байх,

24:02

манай хичээлийн жилийн тухай мэдээлэл танд таалагдсан гэж
найдаж байна.

24:05

Манай багш нар тантай хамтран ажиллах,

24:10

танай хүүхдүүдийг виртуал зайны сургалтанд

24:12

хүлээн авахдаа баяртай байна. Таны хүүхдэд суралцах үнэхээр
сайхан боломж бүрдэнэ гэж найдаж байна.

24:15

Ингээд дахин талархал илэрхийлье.

24:19

Би бол Англи хэл суралцагчдийн албаны эрхлэгч Сэм Клайн
байлаа.

24:22

Танай хүүхдүүд манай сургуульд элсэж, амжилттай суралцахыг
тэсэн ядан хүлээж байна.

24:26

Баярлалаа. Хичээл жилд гялалзсан амжилт хүсье!